Эх сурвалж: Баянбулаг сумын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын үлдэгдэл урьд оноос 87614.4 мянган төгрөг буюу 46.0 хувиар өссөн нь төсвийн байгууллагууд Ковид-19 цар тахалтай холбоотой эм боох материал, тусгай зориулалтын материал, бусад хангамжийн дансанд эм, эмнэлгийн хэрэгсэл, ариутгал халдваргүйжүүлэлтийн материал авч нөөцөлсөн мөн Засаг даргын Тамгын газар

төсвийн хөрөнгөөр худалдан авсан 17300.0 мянган төгрөгийн өвс тэжээлийг зарцуулаагүй үлдэгдлээр тайлагнасан, Сум хөгжүүлэх сангийн хөрөнгөөр худалдан авсан ахуйн үйлчилгээний 4176.8 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг эргэлтийн хөрөнгөөр бүртгэсэн, сургууль аж ахуйн материалын дансанд 13664.7 мянган төгрөгийн дотуур байрны зөөлөн эдлэл, хичээлийн хэрэглэгдэхүүн худалдан авч үлдэгдлээр тайлагнасан нь голлох нөлөөг үзүүлж байна.

Хүснэгт № 5. Бараа материалын үлдэгдэл байгууллагаар /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Засаг даргын тамгын газар	37,368.4	62,952.3	25,583.9	22.6
Иргэдийн төлөөлөгчдийн хурал	1,046.1	1,300.0	253.9	0.5
Соёлын төв	17,182.6	26,157.5	8,974.9	9.4
Сургууль	77,983.7	121,456.7	43,473.0	43.7
Цэцэрлэг	32,538.0	41,604.6	9,066.6	15.0
Эрүүл мэндийн төв	11,764.8	24,476.9	12,712.1	8.8
Орон нутгийн хөгжлийн сан	12,450.0	-	(12,450.0)	-
НИЙТ ДҮН	190,333.7	277,948.1	87,614.4	100.0

Эх сурвалж: Баянбулаг сумын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд нийт нэмэгдсэн 394819.1 мянган төгрөгийн бараа материалын 368356.9 мянган төгрөг нь төсвийн хөрөнгөөр худалдан авсан, 20173.1 мянган төгрөгийн материал шилжүүлэн авсан, 6289.1 мянган төгрөгийн материал дотоод шилжүүлэг болоод бусад хэлбэрээр авсан байна.

Хүснэгт № 6. Бараа материалын орлого, зарлагын төрөл /мянган төгрөг/

Нэмэгдсэн	394,819.1	Хасагдсан	307,204.7
Худалдан авсан	368,356.9	Худалдсан, зарцуулсан	307,129.7
Хандиваар	-	Шилжүүлсэн	-
Шилжүүлэн авсан	20,173.1	Шилжүүлсэн бүтцийн өөрчлөлтөөр	-
Бусад	6,289.1	Бусад	75.0

Эх сурвалж: Баянбулаг сумын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

3.5.7 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 4464915.3 мянга, эцсийн үлдэгдэл 4999153.8 мянган төгрөг болж, 534238.5 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 7. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
БИЕТ ХӨРӨНГӨ	4,414,352.8	4,949,261.3	534,908.5	99.0
Барилга байгууламж, орон сууц	3,362,705.0	3,721,071.8	358,366.9	74.4
Тээврийн хэрэгсэл	183,664.4	241,024.4	57,360.0	4.8
Машин тоног төхөөрөмж	495,545.7	573,300.3	77,754.6	11.5
Тавилга эд хогшил	196,171.2	211,853.9	15,682.7	4.2
Түүх соёлын дурсгалт зүйл	931.6	931.6	-	0.0
Номын фонд	21,943.8	25,791.6	3,847.8	0.5
Бусад үндсэн хөрөнгө	153,391.1	175,287.7	21,896.6	3.5
БИЕТ БУС ХӨРӨНГӨ	50,562.5	49,892.5	(670.0)	1.0
Программ хангамж	3,100.0	2,430.0	(670.0)	0.0
Бусад биет бус хөрөнгө	47,462.5	47,462.5	-	0.9
НИЙТ ДҮН	4,464,915.3	4,999,153.8	534,238.5	100.0

Эх сурвалж: Баянбулаг сумын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд нийт нэмэгдсэн 534238.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгөөс Засаг даргын Тамгын газар 318207.6 мянга, сургууль 41592.2 мянга, цэцэрлэг 96949.9 мянга, Эрүүл мэндийн төв 60901.9 мянган төгрөгөөр үндсэн хөрөнгө өмнөх оноос нэмэгдсэн нь голлох нөлөөг үзүүлж байна.

Хүснэгт № 8. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл байгууллагаар /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Засаг даргын тамгын газар	1,013,440.0	1,331,647.6	318,207.6	26.6
Иргэдийн төлөөлөгчдийн хурал	8,394.0	12,118.5	3,724.5	0.2
Соёлын төв	886,034.9	898,897.4	12,862.5	18.0
Сургууль	805,618.2	847,210.4	41,592.2	16.9
Цэцэрлэг	320,347.8	417,297.6	96,949.9	8.3
Эрүүл мэндийн төв	1,431,080.4	1,491,982.3	60,901.9	29.8
НИЙТ ДҮН	4,464,915.3	4,999,153.8	534,238.5	100.0

Эх сурвалж: Баянбулаг сумын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд шилжүүлэн авсан үнэ төлбөргүй хүлээн авсан 510212.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө нь Засаг даргын Тамгын газар улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 216731.4 мянган төгрөгийн барилгын их засвар, аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 82811.7 мянган төгрөгийн багийн төвийн барилга, өвс тэжээлийн агуулахын барилга, 34000.0 мянган төгрөгийн хогийн машин, цэцэрлэгийн улсын төсвийн хөрөнгө оруулалт болон БСШУЯ-ын хөрөнгө оруулалтаар 65679.8 мянган төгрөгийн барилгын засвар, 5248.5 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, эрүүл мэндийн төв ЭМЯ-ын хөрөнгө оруулалтаар 31500.0 мянган төгрөгийн автомашин, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 24325.9 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг үнэ төлбөргүй хүлээн авч үндсэн хөрөнгийн дансанд бүртгэсэнтэй холбоотой байна.

Хүснэгт № 9. Үндсэн хөрөнгийн орлого, зарлагын төрөл /мянган төгрөг/

Нэмэгдсэн	563,394.5	Хасагдсан	29,156.0
Худалдан авсан	53,182.0	Худалдсан	-
Хандиваар	-	Акталсан	29,156.0
Шилжүүлэн авсан	414,533.2	Шилжүүлсэн	-
Бусад	95,679.4	Бусад	-

Эх сурвалж: Баянбулаг сумын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

3.5.8 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 353.8 мянга, эцсийн үлдэгдэл 2848.2 мянган төгрөг болж 2494.4 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 10. Нийт өр төлбөрийн үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР ДҮН	353.8	2,848.2	2,494.4	100.0
Ажилчидтай холбогдсон өглөг	21.6	459.9	438.3	16.1
Бараа, үйлчилгээний зардлын өглөг	-	2,366.3	2,366.3	83.1
Байгууллагад төлөх өглөг	332.2	22.0	(310.2)	0.8
Дүн	353.8	2,848.2	2,494.4	100.0

Эх сурвалж: Баянбулаг сумын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд 459.9 мянган төгрөгийн ажиллагсадтай холбоотой, 2366.3 мянган төгрөгийн бараа үйлчилгээний зардлын, 22.0 мянган төгрөгийн хувь байгууллагад төлөх өглөг байгаа ба эрүүл мэндийн төвийн санхүүгийн тайланд 2366.3 мянган төгрөгийн шатахууны өглөг үүссэн нь гол нөлөөг үзүүлж байна.

Хүснэгт № 11. Нийт өр төлбөрийн үлдэгдэл байгууллагаар /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Иргэдийн төлөөлөгчдийн хурал	21.6	5.7	(15.8)	0.2
Засаг даргын Тамгын газар	332.2	455.2	123.0	16.0
Цэцэрлэг	-	20.9	20.9	0.7
Эрүүл мэндийн төв	-	2,366.3	2,366.3	83.1
НИЙТ ДҮН	353.8	2,848.2	2,494.4	100.0

3.5.9 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 3980519.9 мянга, эцсийн үлдэгдэл 4443020.0 мянган төгрөг болж, 462500.1 мянган төгрөгөөр төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 12. Засгийн газрын хувь оролцоо /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -	Дүнд эзлэх хувь
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,558,392.2	1,558,392.2	-	35.1
Өмч: - төрийн	1,558,392.2	1,558,392.2	-	35.1
Хуримтлагдсан үр дүн	1,545,646.7	2,010,066.7	464,420.1	45.2
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	876,481.0	874,561.0	(1,920.0)	19.7
Дүн	3,980,519.9	4,443,020.0	462,500.1	100.0

Эх сурвалж: Баянбулаг сумын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 4443020.0 мянган төгрөг болж 462500.1 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн хуримтлагдсан үр дүнгийн 464420.1 мянган төгрөгийн өсөлт, 1920.0 мянган төгрөгийн дахин үнэлгээний нэмэгдэлтэй хөрөнгө акталсантай холбоотой байна.

Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл дансны үлдэгдэл 874561.0 мянган төгрөг болж 1920.0 мянган төгрөгөөр буурсан нь Засаг даргын Тамгын газрын хөрөнгөд бүртгэлтэй 9040.0 мянган төгрөгийн балансын үнэ бүхий Халуун усны барилгыг акталж данснаас хассантай холбоотой байна.

3.5.10 Орлогын данс

Сумын ИТХ-ын 2019.12.16-ны өдрийн хуралдаанаар 10/07 дугаар тогтоолоор сумын төсвийн татварын орлогыг 70980.0 мянга, хүү торгуулийн орлогыг 2500.0 мянга, нийт 73480.0 мянган төгрөгөөр анх баталсан ба 2020.09.30-ны өдрийн 11/02 дугаар тогтоолоор сумын төсөвт төвлөрүүлэх орлогыг нийт 23500.0 мянган төгрөгөөр хасаж тодотгон татварын орлогыг 47480.0 мянга, хүү торгуулийн орлогыг 2500.0 мянган төгрөгөөр баталжээ.

Хүснэгт №13. Төвлөрүүлэх орлого /мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1.Татварын орлого	47,480.0	73,357.0	25,877.0	154.5
1.1.ИОТХ	4,500.0	17,473.6	12,973.6	388.3
1.2. Хадгаламжийн хүүгийн орлого	26,500.0	29,672.5	3,172.5	112.0
1.3. Үл хөдлөх эд хөрөнгө борлуулсны албан татвар	-	162.0	162.0	
1.4.Бууны татвар	2,100.0	1,608.0	(492.0)	76.6
1.5.Улсын тэмдэгтийн хураамж	3,500.0	705.4	(2,794.6)	20.2
1.6. Газрын төлбөр	880.0	735.9	(144.1)	83.6
1.7.Ан агнуурын нөөц ашигласны төлбөр	-	12,800.0	12,800.0	
1.8. Хог хаягдлын үйлчилгээний төлбөр	9,000.0	9,899.1	899.1	110.0
1.9. ТТАМАТөлбөр	1,000.0	300.0	(700.0)	30.0
1.10. Бусад орлого	-	0.4	0.4	
2.Татварын бус орлого	2,500.0	3,934.5	1,434.5	157.4
2.1.Хүү торгуулийн орлого	2,500.0	3,934.5	1,434.5	157.4
Нийт дүн	49,980.0	77,291.48	27,311.5	154.6

Сумын төсөвт төвлөрөх нийт орлогыг 27311.5 мянган төгрөгөөр давуулан биелүүлсэн байгаа ба үүнд ИОТХ 12973.6 мянга, ан агнуурын нөөц ашигласны төлбөрийн орлого 12800.0 мянган төгрөгөөр давж биелсэн нь гол нөлөөг үзүүлж байна. Энэ нь "Эрдэнэс таван толгой" ХХК-ийн ногдол ашгийн татвар 9094.4 мянган төгрөг, мөн шонхор шувууны төлбөр 12800.0 мянган төгрөгийн тус тус төлөвлөгдөөгүй орлого орж ирсэнтэй холбоотой байна.

Сумын ИТХ-ын 2019.12.16-ны өдрийн хуралдаанаар 10/07 дугаар тогтоолоор сумын Засаг даргын Тамгын газрын өөрийн орлогыг нийт 1000.0 мянга, ерөнхий боловсролын сургуулийн орлогыг 1000.0 мянган төгрөгөөр баталсныг 2020.09.30-ны өдрийн 11/02 дугаар тогтоолоор сургуулийн 1000.0 мянган төгрөгийн орлогыг хасаж тодотгосон ба гүйцэтгэлээр Засаг даргын Тамгын газар 1000.0 мянган төгрөгийн орлого оруулсныг тайланд бүртгэжээ.

Сум хөгжүүлэх сангийн зээл, хүүгийн төлөлтөөр тайлант онд 70000.0 мянган төгрөгийг оруулахаар төлөвлөснөөс гүйцэтгэлээр 74510.1 мянга, орон нутгийн хөгжлийн санд өмнөх актын төлбөр 1098.0 мянган төгрөг орсныг орлогоор бүртгэж тайлагнасан байна.

3.5.11 Зардлын данс

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 70105, 70106, 70503, 71602, 71702, 71801, 71802, 71806, 72101 гэсэн кодтой 9 хөтөлбөрт зориулан 2253331.5 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 2106165.5 мянган төгрөгийг гүйцэтгэлээр зарцуулснаас 2021763.1 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулсан бол 84402.4 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд буюу ОНХС-ийн хөрөнгөөс зарцуулсан байна.

3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Улсын /орон нутгийн / төсвийн орлого бүрдүүлэлт

Аймгийн ИТХ-ын 2020 оны төсөв батлах тухай 2019.11.29-ний өдрийн 18/16 дугаар тогтоолд зааснаар Баянбулаг сумын Засаг дарга тайлант онд улсын төсөвт 4600.0 мянга, аймгийн төсөвт 79320.0 мянга, нийт 83920.0 мянган төгрөгийн орлого оруулахаар батлагдсанаас гүйцэтгэлээр 98925.2 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 117.9 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт №14. Улс, аймгийн төсөвт төвлөрүүлэх орлого /мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
А. Улсын төсөв	4,600.0	3,014.9	(1,585.1)	65.5
1. ААНБ-ын орлогын татвар	1,900.0	946.6	(953.4)	49.8
2. Нэмэгдсэн өртгийн албан татвар	2,000.0	1,144.1	(855.9)	57.2
3. Агаарын бохирдол /авто/	700.0	924.2	224.2	132.0
В. Аймгийн төсөв	79,320.0	95,910.3	16,590.3	120.9
1. ЦТХА орлого /Суутган -1/	71,000.0	86,243.6	15,243.6	121.5
2. АТӨЯХ-ийн татвар	6,500.0	7,772.2	1,272.2	119.6
3. ҮХЭХ-ийн татвар	500.0	773.0	273.0	154.6
4. Газрын төлбөр	1,320.0	1,121.5	(198.5)	85.0
Нийт дүн	83,920.0	98,925.2	15,005.2	117.9

Төсвийн төлөвлөлт

Аймгийн СТСХ-ээс авсан судалгаагаар тус төвлөрүүлэн захирагчийн харьяаны 5 төсвийн байгууллага төсвийн төслийг бэлтгэж, аймгийн СТСХ-т хүргүүлж Эрүүл мэндийн төв төсвийн төслийг хүргүүлээгүй ба сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2019.12.16-ний өдрийн 10/07 дугаар тогтоолоор нийт 2216917.1 мянган төгрөгийг баталсан байна.

Хүснэгт №15. Төсвийн төлөвлөлт байгууллагаар /мянган төгрөг/

Орлогын төрөл	Төсвийн төсөл	Анх батлагдсан төсөв	Зөрүү
Иргэдийн төлөөлөгчдийн хурал	69,296.1	80,539.8	11,243.7
Засаг даргын Тамгын газар	419,914.6	408,483.3	(11,431.3)
Сургууль	497,435.7	732,570.1	235,134.4
Цэцэрлэг	279,887.7	285,191.1	5,303.4
Эрүүл мэндийн төв		403,752.6	403,752.6
Соёлын төв	141,223.1	126,222.4	(15,000.7)
Сум хөгжүүлэх сан		72,545.0	72,545.0
Орон нутгийн хөгжлийн сан		107,612.8	107,612.8
Нийт дүн	1,407,757.1	2,216,917.1	809,160.0

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 9 хөтөлбөрийн арга хэмжээний зардалд сумын ИТХ-ын 2019.12.16-ний өдрийн 10/07 дугаар тогтоолоор анх баталсан 2216917.1 мянган төгрөгийг 2020.02.06-ны өдрийн 04 дүгээр тогтоолоор 21972.6 мянга, 2020.09.30-ны өдрийн 11/02 дугаар тогтоолоор 56233.8 мянган төгрөгөөр нэмэгдүүлж баталсан бол тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын зардлыг аймгийн Засаг даргын 2020.11.27-ний өдрийн А/770 дүгээр захирамжаар 13274.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, 2020.12.31-ний өдрийн А/850 дугаар захирамжаар 55066.0 мянган төгрөгөөр бууруулснаар сумын нийт төсөв 2253331.5 мянган төгрөг болжээ.

Нийт зардлын 1246658.5 мянган төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилтээс, 17392.2 мянган төгрөгийг эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилтээс, 66722.0 мянган төгрөгийг орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох санхүүжилтээс, 674861.7 мянган төгрөгийг аймгийн төсвөөс сумын төсөвт олгох санхүүгийн дэмжлэгээс, 49980.0 мянган төгрөгийг сумын орон нутгийн төсвөөс, 71000.0 мянган төгрөгийг төсөвт байгууллагын өөрийн орлогоос, 126717.1 мянган төгрөгийг урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилт, аймгийн төсвөөс авах санхүүгийн дэмжлэгийг бүрэн авч, эрүүл мэндийн даатгалын сангаас олгох санхүүжилтийг 34.0 мянга, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох санхүүжилтийг 13144.1 мянган төгрөгөөр дутуу авсан байна.

Хүснэгт №15. Төсвийн гүйцэтгэл байгууллагаар /мянган төгрөг/

Байгууллагын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь	Төвлөрүүлэлт	
					Улсын төсөв	Орон нутгийн төсөв
Засаг даргын Тамгын газар	421914.3	367795.4	54118.9	87.2	0.0	54997.3
Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	80853.3	77105.8	3747.5	95.4	0.0	2755.8
Ерөнхий боловсролын сургууль	718727.2	687767.9	30959.3	95.7	29510.2	1449.1
Цэцэрлэг	250014.9	245455.9	4559.0	98.2	2437.2	121.8
Эрүүл мэндийн төв	403752.6	400297.6	3455.0	99.1	3365.4	55.7
Соёлын төв	134116.9	132063.5	2053.4	98.5	0.0	2053.4
Орон нутгийн хөгжлийн сан	124257.3	84402.4	39854.9	67.9	0.0	0.0
Сум хөгжүүлэх сан	119695.0	111277.0	8418.0	93.0	0.0	0.0
Нийт дүн	2253331.5	2106165.5	147166.0	93.5	35312.8	61433.0

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2106165.5 мянган төгрөг буюу 93.5 хувьтай байгаа нь Засаг даргын Тамгын газрын урсгал зардлыг 54118.9 мянга, цэцэрлэгийн урсгал зардлыг 4559.0 мянга, ерөнхий боловсролын сургуулийн урсгал зардлыг 28287.5 мянган төгрөгөөр тус тус хэмнэж сум хөгжүүлэх сангаас олгохоор төлөвлөсөн зээлийг 8418.0 мянган төгрөгөөр дутуу, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн төсөл арга хэмжээний санхүүжилтийг 39854.9 мянган төгрөгөөр дутуу олгосон нь голлох нөлөөг үзүүлж байна.

Хүснэгт 16. Баянбулаг сумын Засаг даргын төсвийн гүйцэтгэл, хөтөлбөрөөр /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,253,331.5	2,106,165.5	147,166.0	93.5
70105 ОН-ын өөрөө удирд ёсны байгууллага	80,853.3	77,105.8	3,747.5	95.4
80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	69,899.4	67,188.1	2,711.3	96.1
80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж,	400.0	400.0	-	100.0
80825 Багийн ИНХ-ын даргын урамшуулал	10,553.9	9,517.7	1,036.2	90.2
70106 ОН-ын гүйцэтгэх засаглалын удирдлага	421,914.3	367,795.4	54,118.9	87.2
80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	275,726.0	262,533.0	13,193.0	95.2
80106 Баг, хорооны ҮАЗардал	56,301.8	55,548.5	753.3	98.7
80305 Биеийн тамирын уралдаан, тэмцээн	2,000.0	2,000.0	-	100.0
80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж,	10,000.0	10,000.0	-	100.0
81102 Орон нутгийн нөөц хөрөнгө	68,886.8	28,714.2	40,172.6	41.7

82212 Хур хог хаягдал, орчны бохирдлыг бууруулах	8,999.7	8,999.7	-	100.0
70503 Орон нутгийн зорилтот хөрөнгө оруулалт	124,257.3	84,402.4	39,854.9	67.9
80904 Нийгмийн зориулалттай барилга	124,257.3	84,402.4	39,854.9	67.9
71602 Эмнэлгийн тусламж үйлчилгээ	403,752.6	400,297.6	3,455.0	99.1
80109 ТЗШ-ийн байгууллагуудын тогтмол зардал	22,090.4	22,034.8	55.7	99.7
80302 Нэг иргэнд ногдох нормативаар	13,705.8	13,697.8	8.0	99.9
81603 үндсэн мэргэжлийн тусламж үйлчилгээ	367,956.4	364,565.0	3,391.4	99.1
71702 Соёл урлаг	134,116.9	132,063.5	2,053.4	98.5
80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	131,333.1	130,748.3	584.8	99.6
80214 Уран бүтээл хийлгэх	2,483.8	1,015.2	1,468.6	40.9
80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж,	300.0	300.0	-	100.0
71801 Сургуулийн өмнөх боловсрол	250,014.9	245,455.9	4,559.0	98.2
80103 Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ	10,133.1	9,907.5	225.6	97.8
80109 ТЗШ-ийн байгууллагуудын тогтмол зардал	21,582.1	19,460.3	2,121.8	90.2
80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	3,585.4	3,577.2	8.2	99.8
81807 Цэцэрлэгийн хүүхдийн хоол	15,430.6	15,771.0	(340.4)	102.2
81832 Нүүдлийн бүлэгт хамруулах	128.3	128.3	-	100.0
81833 Явуулын багшийн үйлчилгээ	4,769.6	4,755.0	14.6	99.7
81834 Боловсролын стандарт, сургалтын чанар	169,922.5	169,559.4	363.1	99.8
81835 Сургалтын хэвийн үйл ажиллагаа	24,463.3	22,297.1	2,166.2	91.1
71802 Ерөнхий боловсрол	709,957.9	681,670.4	28,287.5	96.0
80103 Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ	25,616.7	21,834.6	3,782.1	85.2
80109 ТЗШ-ийн байгууллагуудын тогтмол зардал	64,771.5	63,322.4	1,449.1	97.8
80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж,	7,944.9	1,440.0	6,504.9	18.1
81801 үдийн цай хөтөлбөр	13,768.0	9,753.9	4,014.2	70.8
81806 Дотуур байрны үйлчилгээ	88,295.2	82,115.0	6,180.2	93.0
81834 Боловсролын стандарт, сургалтын чанар	392,105.1	387,791.6	4,313.5	98.9
81835 Сургалтын хэвийн үйл ажиллагаа	117,456.5	115,413.0	2,043.5	98.3
71806 Насан туршийн болон албан бус боловсрол	8,769.3	6,097.4	2,671.9	69.5
80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	8,769.3	6,097.4	2,671.9	69.5
72101 Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих	119,695.0	111,277.0	8,418.0	93.0
82611 Жижиг дунд үйлдвэрийг дэмжих	119,695.0	111,277.0	8,418.0	93.0

Эх сурвалж: "Баянбулаг сумын Засаг даргын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан"

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас 5 байгууллага 122877.8 мянга, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоор 2 байгууллага 6032.7 мянга, нийт 128910.5 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Хүснэгт 17. Нэмэлт санхүүжилтийн дансны судалгаа /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	ЗДТГ	ИТХ	Соёл	ЕБС	Цэцэрлэг	ЭМТ	НИЙТ
НИЙТ ОРЛОГО	46,255.7	5,000.0	5,859.9	48,706.0	10,156.1	12,932.8	128,910.5
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	46,255.7	5,000.0	-	48,706.0	10,156.1	12,760.0	122,877.8
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	-	5,859.9	-	-	172.8	6,032.7
НИЙТ ЗАРЛАГА	45,129.0	5,000.0	5,465.3	48,706.0	10,156.1	12,932.8	127,389.2
Бараа, ажил үйлчилгээний зардал	45,129.0	5,000.0	5,465.3	224.5	-	172.8	55,991.6

Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	-	-	5,439.6	-	-	5,439.6
Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	-	-	43,041.9	10,156.1	12,760.0	65,958.0
Төсөвт төвлөрүүлсэн	1,126.7	-	394.7	-	-	-	1,521.4

3.7 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 155 мэдээллээс 152 мэдээллийг хугацаанд нь, 3 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Хүснэгт 17. Шилэн дансны мэдээлэл

д/д	хугацаа	төрөл	удаа	хугацаанд нь мэдээлсэн	хугацаа хоцроосон	хоцроосон мэдээлэл
1	Бүтэн жил	12	12	12	-	-
2	Хагас жил	3	3	3	-	-
3	Улирал бүр	2	8	8	-	-
4	Сар бүр	5	60	60	-	-
5	Тухай бүр	6	72	69	3	Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл, Тухайн байгууллагын хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлт, Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүнг тус тус 5-р сард хоцроож мэдээлсэн
НИЙТ		28	155	152	3	

Эх сурвалж. Баянбулаг сумын Засаг даргын шилэн дансны цахим хуудас

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны санхүүгийн тайланд итгэл үзүүлж аудит хийгдээгүй байна.

3.9 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 6 төсвийн байгууллага, 2 тусгайн сангийн нийт 8 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс бүх байгууллага аудитад хамрагдсан ба 3 байгууллагын санхүүгийн тайланд дүгнэлт гаргаж 3 санхүүгийн тайланд түүвэрт хамруулан Иргэдийн төлөөлөгчдийн хурлын санхүүгийн тайланд итгэл үзүүлсэн байна.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд “Зөрчилгүй” 3, Засаг даргын Тамгын газрын санхүүгийн тайланд “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн байна.

Хүснэгт 21. Хязгаарлалттай дүгнэлт авсан байгууллагууд

БАЙГУУЛЛАГЫН НЭР	ДҮГНЭЛТ ӨГСӨН ГОЛ АСУУДАЛ
"ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ"	
Баянбулаг сумын Засаг даргын Тамгын газар	- Засаг даргын нөөц хөрөнгөөс 6160.0 мянган төгрөгийн автомашин худалдан авч зориулалт бусаар зарцуулсан;
	- Эд хөрөнгийн тооллогын комисс жилийн эцсийн хөрөнгийн тооллого хийхдээ эргэлтийн хөрөнгийн дансанд бүртгэлтэй 63924.4 мянган төгрөгийн хөрөнгийг тоолоогүй, тооллогын дүнгээр тооцоо бодсон акт үйлдэж даргын тушаалаар баталгаажуулаагүй байна. Дээрх алдаа зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3 дахь “санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, 16 дугаар зүйлийн 16.5.5

дахь “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.2.1.2 дахь “энэ журмын 2.1.1, 2.1.2 -т зааснаас бусад зориулалтаар тоног төхөөрөмж бэлтгэх, хөрөнгө оруулалтын зардал гаргахыг хориглоно”, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2018 оны 40 дүгээр тогтоолоор баталсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, шилжүүлэх, акталж данснаас хасах журам-ын 3.6 дахь “Орон нутгийн өмчит хуулийн этгээд нь нь шинээр хөрөнгө олж авахдаа аймгийн Орон нутгийн өмчийн газраас бичгээр зөвшөөрөл авна”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 дахь “нягтлан бодогч нь эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.2 дахь “Байгууллагын нягтлан бодогч нь үндсэн хөрөнгө, бараа материал, үнэ бүхий зүйлийн тооллогоор бэлэн байсан үлдэгдэл, гарсан зөрүүг тооллогын акт материал батлагдсанаас хойш 5 хоногийн дотор нягтлан бодох бүртгэлд тусгаж дансны үлдэгдлийг тулган шалгана” гэсэн заалтуудтай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “Иж бүрэн байх”, “Оршин байх”, “Үнэлгээ” “Үнэн зөв байдал” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяаны төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар нийт 107589.9 мянган төгрөгийн 15 алдаа, зөрчил илэрснээс 6160.0 мянган төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 95441.1 мянган төгрөгийн 4 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 3784.3 мянган төгрөгийн зөрчилд менежментийн захидлаар удирдлагад зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 заалт бүхий зөвлөмж өгч, 2204.6 мянган төгрөгийн 2 алдааг санхүүгийн тайланд залруулжээ.

Баянбулаг сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар нийт 188082.9 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрч 79949.3 мянган төгрөгийн алдааг санхүүгийн тайланд залруулж залруулж, харьяа төсвийн шууд захирагчийн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулах, шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах, сум хөгжүүлэх сангийн зээлийн авлагыг барагдуулах 108133.6 мянган төгрөгийн 3 зөвлөмж өглөө. /Хавсралт 1./

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга

Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланг нэгтгэхдээ харьяа байгууллагуудын аудит хийсэн санхүүгийн тайлангаас зөрүүтэй нэгтгэсэн байна. Үүнд:

- Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайланд сум хөгжүүлэх сангийн зээлийн авлагыг 42769.5 мянган төгрөгөөр зөрүүтэй нэгтгэсэн;
- Санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайланд орон нутгийн төсвөөс төсөвт байгууллагуудад олгосон 750215.2 мянган төгрөгийн санхүүжилт, 61432.9 мянган төгрөгийн төвлөрүүлэх шилжүүлгийн орлогыг цэвэрлээгүй, мөн орон нутгийн хөгжлийн сангийн орон нутгийн төсвөөс олгосон санхүүжилт 8000.0 мянга, өөрийн орлогыг 1098.0 мянга, сум хөгжүүлэх сангийн өөрийн орлогыг 962.7 мянга, үйл ажиллагааны зардлыг 257.0 мянга, ЗДТГ-ын үйл ажиллагааны бус зардлыг 9175.6 мянга, соёлын төвийн бараа үйлчилгээний зардлыг 204.0 мянга нийт 19697.3 мянган төгрөгөөр сангийн яамны Э-тайланд зөрүүтэй нэгтгэсэн, итгэл үзүүлсэн ИТХ-ын өмнөх оны үр дүнгийн тайлангийн орлого 33352.9 мянга, зарлага нь 31040.8 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлан ирүүлсэн;
- Нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайланд мөн дээрх үр дүнгийн тайланд гарсан давтан орон нутгийн төсвөөс төсөвт байгууллагуудад олгосон 750215.2 мянган төгрөгийн санхүүжилт, 61432.9 мянган төгрөгийн төвлөрүүлэх шилжүүлгийн орлогыг цэвэрлээгүй, мөн сум хөгжүүлэх сангийн өөрийн орлогыг 8954.1 мянга, соёлын төвийн өөрийн орлогыг 528.4 мянга, орон нутгийн хөгжлийн сангийн 8000.0 мянган төгрөгийн санхүүжилт, нийт 17482.5 мянган төгрөгөөр сангийн яамны Э-тайланд зөрүүтэй нэгтгэсэн, итгэл үзүүлсэн ИТХ-ын тайлант оны хөрөнгийн зардал 3924.5 мянган төгрөгийн хөрөнгийн зардлыг тохируулаагүй;

3.10 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Санхүүгийн тайлангийн завсрын аудитаар аудитлагдсан тайлангийн 2020 оны эцсийн үлдэгдлийг Э-тайлангийн 2021 оны эхний үлдэгдлээр зөв оруулсан эсэхийг нягталж тодруулах шаардлагатай мөн нягтлан бодогч нарын хариуцлагыг дээшлүүлэн санхүүгийн программын эцсийн үлдэгдлийг э-тайлангийн үлдэгдлээр зөв хаалт хийсэн эсэх дээр Баянбулаг сумын Санхүүгийн албаны дарга хянаж, дотоод хяналтыг сайжруулах шаардлагатай байна.

4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 УДИРДЛАГЫН ДЭЭД БОЛОН ДОТООД ХЯНАЛТ

3.1.1. **Илрүүлэлт:** Төсөвт байгууллага, сангийн нягтлан бодогч нар Сангийн яамны Э-тайланд санхүүгийн тайланд хөрөнгө материал, орлого, зарлагын төрлийг зөрүүтэй тайлагнасан, төсөвт байгууллагууд нь хөрөнгө материалыг аваагүй байхад тодотгол хийж хөрөнгө бэлтгэхээр ААНБ-д мөнгийг шилжүүлж авлага үүсгэсэн, төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан, анхан шатны баримтын бүрдэлгүй гүйлгээ хийсэн зөрчил санхүүгийн тайлангийн аудитаар илэрч 1 байгууллага “Хязгаарлалттай” дүгнэлт авсан байхад сумын төрийн сан хяналт тавьж ажиллаагүй, итгэл үзүүлсэн ИТХ нь аудитын тайланг буруу гаргаж, Э-тайлангаас 68318.2 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлан ирүүлсэн байхад сумын санхүүгийн албаны дарга хяналт тавьж ажиллаагүй байна.

Энэ нь “Үнэн зөв байдал”, “Хэмжилт” гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төсвийн тухай хууль, Сангийн сайдын 55 дугаар тушаалыг тус тус зөрчсөн байна.

3.1.2. **Эрсдэл:** Харьяа байгууллагуудын аудитаар илэрсэн материаллаг хэмжээний алдаа зөрчлийн дүн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн хүлээн зөвшөөрөгдөх материаллаг байдлаас хэтэрсэн байх.

3.1.3 **Өгсөн зөвлөмж:** Сумын төсөвт байгууллагуудын нягтлан бодох бүртгэл, анхан шатны баримтын бүрдэл, санхүүгийн тайлангийн үнэн зөв гаргасан байдал, аудитлагдсан санхүүгийн тайланг Сангийн яамны Э-тайланд хөрөнгө, орлого, зарлагыг данс бүрээр тайлагнаж байгаад тавих Төрийн сангийн дотоод хяналтыг сайжруулах.

3.1.4 **Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:** Хүлээн зөвшөөрсөн.

3.2. УДИРДЛАГЫН ДЭЭД БОЛОН ДОТООД ХЯНАЛТ

3.2.1. **Илрүүлэлт:** Сум хөгжүүлэх сангаас олгосон хөнгөлөлттэй зээлийн 191596.5 мянган төгрөгийн үлдэгдлээс 10 зээлдэгчийн 39815.4 мянган төгрөгийн зээл, зээлийн хүүгийн үлдэгдэл нь 2012-2017 онуудад олгосон гэрээ хугацаа дуусаж хэтэрсэн байхад хяналт тавьж, хугацаа хэтэрсэн зээлийг төлүүлээгүй байна.

Энэ нь Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолоор батлагдсан “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам”-ын 4.7 дахь Иргэн, хуулийн этгээд авсан зээл, зээлийн хүүг гэрээнд заасан хугацаанд сангийн дансанд буцаан төлнө” заалтыг зөрчсөн байна.

3.2.2 **Эрсдэл:** Сангийн хөрөнгөөс олгосон зээл гэрээнд заасан хугацаанд төлөгдөхгүй сан хохирох, дараагийн зээлдэгч сангаас зээл авах боломжгүй болох.

3.2.3 **Өгсөн зөвлөмж:** Сум хөгжүүлэх сангийн хөрөнгөөс хөнгөлөлттэй зээл авч хугацаандаа төлөөгүй 10 зээлдэгчийн 39815.4 мянган төгрөгийн зээл, зээлийн хүүг 2021 оны 06 дугаар сарын 25-ны дотор төлүүлэх арга хэмжээ авч, заасан хугацаанд төлөөгүй иргэдийг хууль хяналтын байгууллагад шилжүүлэх.

3.2.4 **Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:** Хүлээн зөвшөөрсөн.

3.3. УДИРДЛАГЫН ДЭЭД БОЛОН ДОТООД ХЯНАЛТ

3.3.1 **Илрүүлэлт:**

Шилэн дансны тухай хуулийг бүрэн хэрэгжүүлээгүйгээс шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 155 мэдээллээс 152 мэдээллийг хугацаанд нь мэдээлж, 3 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх "Мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх зарчмыг баримтална" гэснийг зөрчсөн байна.

3.3.2 **Эрсдэл:** Төсвийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор төсвийн удирдлагыг хэрэгжүүлэх шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоо бүрдүүлэхгүй байх.

3.3.3 **Өгсөн зөвлөмж:** Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж, мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст хугацаанд нь бүрэн байршуулж, түүнд тавих хяналтыг сайжруулах.

3.3.4 **Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:** Хүлээн зөвшөөрсөн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 06 дугаар сарын 25-ний дотор нотлох баримтын хамт ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ:

Бэлтгэсэн:
АУДИТОР

Ж.ӨСӨХБАЯР 2021.03.25

Анхан шатанд хянасан:
АУДИТЫН МЕНЕЖЕР

А.ЦЭЭНЯМ 2021.03.25

Хоёр дахь шатанд хянасан:
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.МӨНХБАТ 2021.03.25



5. Хавсралт 1.: Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо	Аудитын нэр:	Баянбулаг сумын Засаг даргын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудит	Аудитын код:		
2020			БНА-2021/3/СТА-ТТЗ		
Шалгагдсан байгууллагын нэр:		Баянбулаг сумын Засаг дарга	Мянган төгрөг		
№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
A	1	2	3	4	5
1	Сумын Засаг даргын нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан, үр дүн, мөнгөн гүйлгээний тайлангийн үзүүлэлтийг зөрүүтэй илэрхийлсэн байна.	79949.3	Санхүүгийн тайланд залруулсан.	Сумын Засаг дарга, санхүүгийн албаны дарга	Д.Пүрэвсүрэн, Л.Дулмаа
2	Төсөвт байгууллага, сангийн нягтлан бодогч нар Сангийн яамны Э-тайланд санхүүгийн тайланд хөрөнгө материал, орлого, зарлагын төрлийг зөрүүтэй тайлагнасан, харьяа төсвийн шууд захирагчийн байгууллагууд нь хөрөнгө материалыг аваагүй байхад тодотгол хийж хөрөнгө бэлтгэхээр ААНБ-д мөнгийг шилжүүлж авлага үүсгэсэн, төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан, анхан шатны баримтын бүрдэлгүй гүйлгээ хийсэн зөрчил санхүүгийн тайлангийн аудитаар илэрч 1 байгууллага "Хязгаарлалттай" дүгнэлт авсан байхад сумын санхүүгийн албаны дарга хяналт тавьж ажиллаагүй итгэл үзүүлсэн ИТХ нь аудитын тайланг буруу гаргаж, Э-тайлангаас зөрүүтэй тайлан ирүүлсэн.	68318.2	Зөвлөмж өгсөн.	Сумын Засаг дарга, санхүүгийн албаны дарга	Д.Пүрэвсүрэн, Л.Дулмаа
3	Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлээгүйгээс 3 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн.	-	Зөвлөмж өгсөн.	Сумын Засаг дарга, санхүүгийн албаны дарга	Д.Пүрэвсүрэн, Л.Дулмаа
4	Сум хөгжүүлэх сангаас олгосон хөнгөлөлттэй зээлийн 191596.5 мянган төгрөгийн үлдэгдлээс 10 зээлдэгчийн 39815.4 мянган төгрөгийн зээл, зээлийн хүүгийн үлдэгдэл нь 2012-2017 онуудад олгосон гэрээ хугацаа дуусаж хэтэрсэн байхад хяналт тавьж, хугацаа хэтэрсэн зээлийг төлүүлээгүй байна.	39815.4	Зөвлөмж өгсөн.	Сумын Засаг дарга, санхүүгийн албаны дарга	Д.Пүрэвсүрэн, Л.Дулмаа
Төсвийн төвлөрүүлэн захирагчийн дүн		188082.9			
Харьяа төсвийн байгууллагуудын дүн		107589.9			
Цэцэрлэг		2988.9			
1	Цалин, НДШ-ийн зардлыг анхан шатны баримтаас түүвэрлэн үр дүнгийн тайлан, НДШ-ийн тайлантай тулган баталгаажуулахад даатгуулагчаас төлсөн НДШ-ийн 1204.6 мянган төгрөгийг ажил олгогчийн НДШ-ийн зардлаар тайлагнасан	1,204.6	Санхүүгийн тайланд залруулсан	эрхлэгч, нягтлан бодогч	Л.Энхцэцэг, С.Ганболд
2	2020 оны 6 дугаар сард ажилтнуудын 2 дугаар улирлын үр дүнгийн урамшуулалт цалин 1784.3 мянган төгрөгийг цалингийн цэстэд 2 дахин оруулж бодон олгоод Нийгмийн даатгалын байгууллага, татварын байгууллагад цалинг илүү мэдээлсэн бөгөөд 12 дугаар сард буцаан суутгахдаа бодогдсон цалингаар суутгалыг хийснээс өглөг, авлагын тооцоо үүссэн боловч залруулга хийх боломжгүй байна.	1,784.3	Зөвлөмж өгсөн	эрхлэгч, нягтлан бодогч	Л.Энхцэцэг, С.Ганболд
3	Санхүүгийн тайланд хөрөнгийн дахин үнэлгээ данс 184431.9 мянган төгрөгөөр, ҮХ-ийн дэлгэрэнгүй журналд 75294.9 мянган төгрөгөөр, ОНӨГ-ын дахин үнэлгээний нэгтгэлд 245320.0 мянган төгрөгөөр тус тус зөрүүтэй бүртгэгдсэн	-	Зөвлөмж өгсөн	эрхлэгч, нягтлан бодогч	Л.Энхцэцэг, С.Ганболд
Сургууль		-			
4	Шилэн дансны мэдээллийн сайтад нийт 27 төрлийн 151 мэдээлэл байршуулахаас 139 мэдээллийг хугацаанд нь 6 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан	-	Зөвлөмж өгсөн	Захирал, нягтлан бодогч	Э.Нандинбилэг, С.Ганболд
5	НББ-ийн бодлогын баримт бичиг байгаа боловч байгууллагын даргын тушаалаар баталгаажуулаагүй байна.	-	Зөвлөмж өгсөн	Захирал, нягтлан бодогч	Э.Нандинбилэг, С.Ганболд
Засаг даргын Тамгын газар		102601.0			
6	Сумын Засаг даргын 2020 оны А/113 дугаар захирамжаар томилсон нь байгууллагын үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй хөрөнгүүдийг тоолсон	63,924.4	Албан шаардлага өгсөн	Дарга, нягтлан бодогч	Д.Цэнд-Аюуш, Ц.Нямдорж

Баянбулаг сумын Засаг даргын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
	ч эргэлтийн хөрөнгийн дансанд бүртгэлтэй 63924448 төгрөгийн хөрөнгийн тоолоогүй байна.				
7	Тайлант хугацааны эргэлтийн хөрөнгийн нярвын тайлангийн нийт орлого 1420.7 мянган төгрөг, нийт зарлага 11658.5 мянган төгрөг эцсийн үлдэгдэл нь 10237.8 мянган төгрөгөөр нягтлан бодогчийн бүртгэлээс зөрүүтэй байна.	10,237.8	Албан шаардлага өгсөн	Дарга, нягтлан бодогч	Д.Цэнд-Аюуш, Ц.Нямдорж
8	Тайлант хугацаанд төсөвт байгууллагын өөрийн орлогоор 1000.0 мянган төгрөгийн орлого төвлөрсөн байхад тус орлогыг санхүүжилтийн орлогоор бүртгэсэн байна.	1,000.0	Санхүүгийн тайланд залруулсан	Дарга, нягтлан бодогч	Д.Цэнд-Аюуш, Ц.Нямдорж
9	Сумын Засаг даргын 2020.12.17-ны өдрийн Б/120 тоот захирамжаар Засаг даргын нөөц хөрөнгөөс сумын цагдаагийн хэсэгт 7000.0 мянган төгрөгөөр автомашин авах шийдвэр гарсны дагуу 2020.12.16-ны өдөр иргэн Б.Төрбаттай гэрээ байгуулан 6160.0 мянган төгрөгөөр "probox" маркийн автомашин худалдан авсан байна.	6,160.0	Төлбөрийн акт тогтоосон	Дарга, нягтлан бодогч	Д.Цэнд-Аюуш, Ц.Нямдорж
10	Тус байгууллага нь Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг байхгүй байна.	-	Зөвлөмж өгсөн	Дарга, нягтлан бодогч	Д.Цэнд-Аюуш, Ц.Нямдорж
11	Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 2020 онд нийт 151 мэдээлэл оруулахаас бүтэн жилээр болон тухай бүр оруулах худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан бусад хяналт шалгалтын дүн гэсэн 45423.3 мянган төгрөгийн 4 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.	-	Зөвлөмж өгсөн	Дарга, нягтлан бодогч	Д.Цэнд-Аюуш, Ц.Нямдорж
12	Ажиллагсдын цалингийн санг 2020 оны 2, 6, дугаар саруудад нийт 1215831 төгрөгөөр Нийгмийн даатгалын хэлтэст дутуу мэдээлсэн.	1,215.8	Албан шаардлага өгсөн	Дарга, нягтлан бодогч	Д.Цэнд-Аюуш, Ц.Нямдорж
13	Баянхонгор аймгийн Сум дундын Ойн ангийн нягтлан бодогчийн ирүүлсэн тус байгууллагад олгосон өвс тэжээлийн тооцоогоор 2020 онд нийт 42672.0 мянган төгрөгийн өвс тэжээл нийлүүлж 20063.0 мянган төгрөгийн авлагатай гарсан байхад тооцоо актаар баталгаажуулаагүй.	20,063.0	Албан шаардлага өгсөн	Дарга, нягтлан бодогч	Д.Цэнд-Аюуш, Ц.Нямдорж
Эрүүл мэндийн төв		2000.0			
14	Батлагдсан төсөвт зардлыг дүнгээр нь хэтрүүлээгүй боловч зардлын ангиллаар авч үзэхэд шатахууны зардалд 21086.1 мянган төгрөгийн төсөв батлагдаж 20719.9 мянган төгрөгийг зарцуулсан атлаа 2366.3 мянган төгрөгийн өртэй гарсан нь төсвийн зарцуулаагүй үлдэгдлийг хасаж тооцоход батлагдсан төсвийг 2000.0 мянган төгрөгөөр хэтрүүлсэн байна	2,000.0	Зөвлөмж өгсөн	ЭМТ-ийн дарга, нягтлан бодогч	О.Гандиймаа, Д.Жавхлан
15	санхүүгийн тайланд хөрөнгийн дахин үнэлгээ данс 57267,3 мянган төгрөгөөр зөрүүтэй тусгагдсан нь хэдэн онд үнэлэгдсэн ямар хөрөнгийн дахин үнэлгээ бүртгэлтэй байгаа болон ямар хөрөнгийн дахин үнэлгээ хэрэгжсэн эсэх нь тодорхойгүй байна.	-	Зөвлөмж өгсөн	ЭМТ-ийн дарга, нягтлан бодогч	О.Гандиймаа, Д.Жавхлан

ОО